

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Зэрэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: ХОА-2021/78/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг Утас: 70432545 цахим хаяг: ErdenetsetsegD@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
АОУС	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
УСНББОУС	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
ТТЗ	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
ТШЗ	<i>Төсвийн шууд захирагч</i>
ЕБС	<i>Ерөнхий боловсролын сургууль</i>
НДШ	<i>Нийгмийн даатгалын шимтгэл</i>
ХАОАТ	<i>Хүн амын орлогын албан татвар</i>
ЗДТГ	<i>Засаг даргын тамгын газар</i>
СТСХ	<i>Санхүү, Төрийн сангийн хэлтэс</i>
БШУЯ	<i>Боловсрол шинжлэх ухааны яам</i>

Агуулга

1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

1.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав бөг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЗЭРЭГ СУМЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ч.ТӨМӨРМӨНХ ТАНАА

2021.02.25 № 2/158
танай -ны № -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зэрэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас Зэрэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаатай, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан сургалтын чанар, элсэлтийн шалгалтын бодит байдал /суралцагчийн сурлагын түвшин, суралцагчийн сурах зэлтэй орчин бүрдүүлсэн / зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг/ агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангаар төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт бодит бус, зарцуулалт бусаар гүйлгэн зарцуулсан, үдийн цай, хүүхдийн хоолны норматив зардлын хэмнэлтийг төсөвт төвлөрүүлээгүй, авлага, өлөгийн тооцоо хийж баталгаажуулаагүй, дотуур байрны хүүхдээс болон хандиваар авсан мөнгөний зарцуулалтын тооцоо хийгээгүй, үдийн цай болон хүнс нийлүүлж байгаа аж ахуйн нэгжүүдийн гэрээ дүгнээгүй, нярвын аж ахуйн тайлан засвар ихтэй, хүүхдийн хоолны талон батлуулаагүй хүнс зарлагдсан, анхан шатны баримтын бүрдэл хангалтагүй, хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгийн зардалд тавих дотоод хяналт сул зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн

021020655

зрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцрог хянаж ажил, гүйцээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангаасан байх", СС-ийн 216 тоот тушаалаар батлагдсан төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, НББ-д тусгах журмын 2-р зүйлийн 2.2.1-д "нэгжид ноогдох норм, нормативаар тооцсон төсвийн гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээ, багассанаас бий болсон /сургуулийн хүүхдийн тоо.../ зарцуулагдаагүй үлдээгдлийг төсвийн зарлагын хэмнэлд тооцохгүй, гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлан нь "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал", "оршин байх", "толилуулга ба тодруулга", "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдээдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн адийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

төгрөгөөр

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>69,841,595.73</u>	<u>80,397,613.65</u>
АВЛАГА	6,352.08	00.00
Ажиллагчидтай холбогдсон авлага	6,352.08	00.00
БАРАА МАТЕРИАЛ	69,835,243.65	80,397,613.65
Түүхий эд материал	527,875.00	2,671,735.00
Тусгай зориулалттай материал	228,000.00	00.00
Эм боох материал	299,875.00	2,671,735.00
Хангамжийн материал	69,307,368.65	77,725,878.65
Бичиг хэргийн материал	4,202,920.51	4,347,620.51
Аж ахуйн материал	1,822,000.00	5,319,060.00
Сэлбэг хэрэгсэл	191,000.00	306,500.00
Барилгын засварын материал	1,640,000.00	2,072,975.00
Хүнсний материал	1,915,150.50	4,095,425.50
Бусад хангамжийн материал	59,536,297.64	61,584,297.64
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,918,387,021.68</u>	<u>2,128,812,004.44</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,918,387,021.68	2,128,812,004.44
Биет хөрөнгө	1,889,487,021.68	2,099,912,004.44
Барилга, байгууламж, орон сууц	1,943,243,411.03	2,206,860,886.03
Хуримтлагдсан элэгдэл	-169,080,212.21	-214,788,213.05
Авто-тээврийн хэрэгсэл	7,500,000.00	7,500,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-7,500,000.00	-7,500,000.00
Машин тоног төхөөрөмж (компьютер)	279,560,198.55	283,532,515.83
Хуримтлагдсан элэгдэл	-226,717,861.05	-238,035,522.40
Тавилга, аж ахуйн эд хогшил	115,986,470.00	115,407,803.60
Хуримтлагдсан элэгдэл	-81,858,215.50	-80,404,391.20
Бусад үндсэн хөрөнгө	32,706,184.00	23,930,644.00
Хуримтлагдсан элэгдэл	-27,827,511.28	-21,796,578.85
Ном	23,474,558.14	25,204,860.48
Биет бус хөрөнгө	28,900,000.00	28,900,000.00
Бусад биет бус хөрөнгө	57,900,000.00	57,900,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-29,000,000.00	-29,000,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,988,228,617.41</u>	<u>2,209,209,618.09</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,250,441.00</u>	<u>00.00</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,250,441.00	00.00
Өглөг	2,250,441.00	00.00
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,705,941.00	00.00
Бусад өглөг	544,500.00	00.00
Байгууллагад төлөх өглөг	544,500.00	00.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,985,978,176.41</u>	<u>2,209,209,618.09</u>
Засгийн газрын хувь оролцоо	1,985,978,176.41	2,209,209,618.09

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,284,454,207.00	1,284,454,207.00
Өмч: - төрийн	1,284,454,207.00	1,284,454,207.00
Хуримтлагдсан үр дүн	91,371,925.82	314,603,367.50
Өмнөх үеийн үр дүн	91,371,925.82	91,371,925.82
Тайлант үеийн үр дүн	00.00	223,231,441.68
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	610,152,043.59	610,152,043.59
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,988,228,617.41	2,209,209,618.09

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,055,964,395.00	1,575,953,654.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,401,875.00	1,433,470,654.09
120	Нийтлэг татварын бус орлого	2,401,875.00	340,135,454.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,401,875.00	340,135,454.09
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	400,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,401,875.00	339,735,454.09
120009	Бусад орлого	00.00	
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	1,093,335,200.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	1,093,335,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	742,274,320.00	142,483,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,827,020.00	1,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,827,020.00	1,300,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	141,183,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	141,183,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,080,554,179.15	1,348,274,753.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,080,554,179.15	1,348,274,753.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,051,064,979.15	1,271,293,241.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	726,514,000.00	852,892,802.00
210101	Үндсэн цалин	674,239,603.00	572,066,773.00
210102	Нэмэгдэл	52,274,397.00	198,495,162.00
210104	Урамшуулал	00.00	82,330,867.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,887,202.93	107,545,171.00
210201	Тэтгэврийн даатгал	61,913,243.97	73,429,458.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,243,605.99	8,528,928.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,794,884.99	6,823,142.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,448,258.00	1,705,787.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,487,209.98	17,057,856.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,025,600.00	139,165,025.00

210301	Гэрэл, цахилгаан	8,767,300.00	4,776,025.00
210302	Түлш, халаалт	108,006,500.00	114,637,200.00
210303	Цэвэр, бохир ус	16,251,800.00	19,751,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,744,563.16	6,273,858.00
210401	Бичиг хэрэг	4,676,763.16	2,004,768.00
210402	Тээвэр, шатахуун	4,790,141.00	2,597,090.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	286,500.00	598,000.00
210404	Ном, хэвлэл	38,000.00	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,903,159.00	602,500.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	251,500.00
2105	Нормативт зардал	62,496,699.50	37,524,515.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	508,000.00	2,055,040.00
210502	Хоол, хүнс	61,988,699.50	35,469,475.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,106,810.00	720,000.00
210604	Урсгал засвар	8,106,810.00	720,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	225,600.00	392,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	225,600.00	392,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,748,603.56	126,779,870.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	382,040.00	1,997,809.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,366,525.00	1,060,949.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,000,038.56	123,721,111.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,489,200.00	76,981,511.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,489,200.00	74,956,350.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,489,200.00	17,156,350.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	57,800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	2,025,161.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,025,161.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-24,589,784.15	227,678,901.02
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	4,447,459.34
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	4,447,459.34
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-4,447,459.34
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-24,589,784.15	223,231,441.68

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,054,529,670.00	1,236,218,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,200,000.00	1,200,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,200,000.00	1,200,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,200,000.00	1,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,200,000.00	1,200,000.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	734,447,300.00	1,107,612,761.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,053,329,670.00	1,235,018,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	734,447,300.00	1,107,612,761.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	311,288,200.00	126,105,439.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,594,170.00	1,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,594,170.00	1,300,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,054,529,670.00	1,236,218,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,054,529,670.00	1,236,218,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,025,655,090.00	1,157,694,738.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	734,103,995.00	854,474,104.00
210101	Үндсэн цалин	534,154,475.00	599,059,926.00
210102	Нэмэгдэл	153,694,227.00	201,082,978.00
210104	Урамшуулал	46,255,293.00	54,331,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,590,630.00	107,545,171.00
210201	Тэтгэврийн даатгал	55,141,909.00	73,575,471.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,187,437.00	8,492,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,615,600.00	6,794,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,268,784.00	1,698,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,376,900.00	16,984,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,025,600.00	140,532,999.50
210301	Гэрэл, цахилгаан	8,767,300.00	6,143,999.50
210302	Түлш, халаалт	108,006,500.00	114,637,200.00
210303	Цэвэр, бохир ус	16,251,800.00	19,751,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,215,755.00	4,183,300.00
210401	Бичиг хэрэг	533,400.00	444,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,805,580.00	1,376,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	286,500.00	598,000.00
210404	Ном, хэвлэл	1,365,575.00	233,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	234,600.00	234,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	990,100.00	1,295,800.00
2105	Нормативт зардал	55,192,750.00	44,807,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	508,000.00	4,427,800.00
210502	Хоол, хүнс	54,469,350.00	38,194,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	215,400.00	2,185,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,379,100.00	650,000.00
210604	Урсгал засвар	2,379,100.00	650,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,040,400.00	392,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	225,600.00	392,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,790,960.00	5,110,064.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	905,700.00	837,264.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,885,260.00	4,272,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,874,580.00	78,523,461.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,947,250.00	76,498,300.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,947,250.00	18,698,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	57,800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	927,330.00	2,025,161.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	927,330.00	2,025,161.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,284,454,207.00	610,152,043.59	91,371,925.82	1,985,978,176.41
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,284,454,207.00	610,152,043.59	91,371,925.82	1,985,978,176.41
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,284,454,207.00	610,152,043.59	91,371,925.82	1,985,978,176.41
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	223,231,441.68	223,231,441.68
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,284,454,207.00	610,152,043.59	314,603,367.50	2,209,209,618.09

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Анх батлагдсан төлөвлөгөө	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,205,331,800.00	1,235,689,800.00	1,232,893,038.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,205,331,800.00	1,235,689,800.00	1,232,893,038.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,154,544,800.00	1,159,181,600.00	1,156,394,738.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	789,892,700.00	849,242,700.00	849,920,044.00
210101	Үндсэн цалин	564,952,000.00	564,952,000.00	692,192,259.00
210102	Нэмэгдэл	165,620,700.00	224,970,700.00	106,786,100.00
210104	Урамшуулал	59,320,000.00	59,320,000.00	50,941,685.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,635,400.00	114,647,700.00	107,545,171.00
210201	Тэтгэврийн даатгал	75,039,900.00	80,678,000.00	107,545,171.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	145,902,300.00	140,533,000.00	139,165,025.00
210301	Гэрэл, цахилгаан	9,644,000.00	9,644,000.00	4,835,629.00
210302	Түлш, халаалт	120,006,500.00	114,637,200.00	114,637,200.00
210303	Цэвэр, бохир ус	16,251,800.00	16,251,800.00	19,692,196.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,448,800.00	4,448,800.00	6,314,316.00
210401	Бичиг хэрэг	487,300.00	487,300.00	1,862,188.00
210402	Тээвэр, шатахуун	1,376,900.00	1,376,900.00	2,529,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	621,000.00	621,000.00	693,800.00
210404	Ном, хэвлэл	433,200.00	433,200.00	55,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	234,600.00	234,600.00	247,528.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,295,800.00	1,295,800.00	926,600.00
2105	Нормативт зардал	100,863,300.00	43,507,100.00	43,123,773.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	346,800.00	3,127,800.00	354,200.00
210502	Хоол, хүнс	98,737,100.00	38,194,300.00	37,788,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,779,400.00	2,185,000.00	4,980,873.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,421,600.00	1,421,600.00	1,724,669.50
210604	Урсгал засвар	1,421,600.00	1,421,600.00	1,724,669.50
2107	Томилолт, зочны зардал	315,900.00	315,900.00	355,100.00
210702	Дотоод албан томилолт	315,900.00	315,900.00	355,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	392,000.00	392,000.00	400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392,000.00	392,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,672,800.00	4,672,800.00	7846640.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00	400,000.00	976,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,272,800.00	4,272,800.00	6,870,240.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,787,000.00	76,508,200.00	76,498,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,787,000.00	76,508,200.00	76,498,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,787,000.00	18,708,200.00	18,698,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	57,800,000.00	57,800,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,205,331,800.00	1,235,689,800.00	1,232,893,038.50
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,057,607,900.00	1,093,335,200.00	1,091,310,038.50
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,057,607,900.00	1,093,335,200.00	1,091,310,038.50
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	147,323,900.00	141,954,600.00	141,183,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	147,323,900.00	141,954,600.00	141,183,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	400,000.00	400,000.00	400,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,000.00	400,000.00	400,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	69.00	69.00	71.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	40.00	40.00	41.00
620003	Үйлчлэх ажилтан	28.00	28.00	29.00

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,300,000
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,300,000
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,300,000
2105	Нормативт зардал	1,300,000
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,300,000
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,300,000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,300,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	800,000

131106	Төсвийн урамшуулал	00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Зэрэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Ч.Төмөрмөнх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагын ойн хандивын зарцуулалт, дотуур байрны хүүхдээс авсан мөнгөн хөрөнгийн зарцуулалт, шимтгэлийн тооцоог дахин хянах, хүүхдийн хоолны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 20-ноос 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь Ковид -19 цар тахлын үеийн хөл хорио тогтоолт, нягтлан бодогчийн ажлын хариуцлага сул зэргээс хамааран 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2021 оны дүгээр сарын .. өдөр Төрийн аудитын байгууллагад ирүүлж хуулийн хугацаа хоцроосон, аудитад шаардлагатай зарим мэдээ, мэдээллийг тулган баталгаажуулах шаардлагатай зэргээс хамаарч аудитын тайлангийн хугацаа хоцорсон болно.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хүүхдийн сурах үйлийг дэмжиж сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшил, сурлагын амжилт чанарыг сайжруулах, багшийн мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх зорилго дэвшүүлэн ажиллажээ. Байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь:

- ✓ Ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага
- ✓ Эх хэлний чадварыг хөгжүүлэх
- ✓ Боловсролын үйлчилгээнд хүн бүр оролцогч байх чадамжийг дээшлүүлэх
- ✓ Суралцах чадвар, сургалтын чанарт ахиц гаргах
- ✓ Хүүхдэд ээлтэй эрүүл орчин бүрдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Зэрэг сумын ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг БШУЯ-наас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор БСУГ-ын дотоод хяналт болон бусад хяналтын байгууллагууд 2020 онд тус байгууллагад хяналт хэрэгжүүлээгүй боловч сумын Төрийн сангаас өдөр тутмын санхүүгийн гүйлгээнд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүд хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайлан мэдээ байхгүй байна.

Зэрэг сумын ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинд “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 845500.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 8450.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 1352725.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 13527.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зэрэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 220981.0 мянган төгрөгөөр буюу 25.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	6.3	0.0	-6.3
БАРАА МАТЕРИАЛ	69,835.3	80,397.6	10,562.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,918,387.0	2,128,812.0	210,425.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,988,228.6	2,209,209.6	220,981.0
БОГИНО ХУГАЦААТ ӨР	2,250.4	0.0	-2,250.4
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН	1,985,978.2	2,209,209.6	223,231.4
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР	1,988,228.6	2,209,209.6	220,981.0

Авлага дансны үлдэгдэл оны эцэст авлагын үлдэгдэлгүй байна. Тайлант онд аж ахуйн нэгж байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулсан боловч ажилчидтай холбогдох ашгийн татвар илүү төлөөд авлагаар тусгаагүй, цалинтай холбоотой

тооцоог татвар, даатгалын байгууллагатай тооцоо хийж тооцоо нийлсэн актаар авлагагүй гэж хоорондын тооцоог баталгаажуулсан байна.

Зэрэг Шим-Ус ОНӨҮГ-т нэхэмжлэлээс илүү мөнгө төлөөд авлагаар тусгаж өр авлагын тооцоо нийлээгүй байна. Мөн сургуулийн ойд зориулж иргэдээс авсан хандивыг хувь дансаар оруулсан, авлага тусгаж тайлан баланст тусгаагүй зарцуулалтын тайлан байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 80397.6 мянган төгрөг болж 10562.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд эм, ариутгалын бодис болон ажилчдын нормын хувцас, хүнс нөөцөлж авсан байгаа нь нөлөөлж байна. Бараа материалын зардлаас хүнсний материал оны эхэнд 4500.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байснаас оны эцэст 4409.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь зарим муудах хүнсний материал байх эрсдэлтэй байна. Дотуур байрны хүүхдээс өрөө тохижуулах хуримтлал цуглуулж аж ахуйн материал авсан боловч данс бүртгэлд тусгаагүй зарцуулалтын тайлан гаргаагүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1918387.0 мянган төгрөг, оны эцэст 2128812.0 мянган төгрөг болж 210425.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь тайлант онд төсвийн хөрөнгөөр төсвийн хөрөнгөөр 926.6 мянган төгрөгийн ус буцалгагч, УТХО-аар 268881.0 мянган төгрөгийн их засвар, СОНХС-аас 25965.5 мянган төгрөгийн хашаа, БСУГ-аас 27190.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Зэрэг сумын ЗДТГ-аас 1560.0 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, АОНХС-аас 4938.0 мянган төгрөгийн хүүхдийн ширээ сандал, төгсөгчдийн хандиваар 2880.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг 2020.12.30-ны 267 тоот ИТХ-ын тогтоолоор үнэ төлбөргүй орлогоор авч, ДЗОУБ-аас 2618.1 мянган төгрөгийн ном үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн. Зэрэг сумын ИТХ-ын 2021.01.13-ны 04 тоот тогтоолоор 78627.6 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хасалт хийж тайлагнасан байна. Тайлант онд бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй байна.

Өр төлбөр оны эхэнд 2250.4 мянган төгрөгийн аж ахуйн нэгжтэй холбогдсон өглөгтэй байснаас тайлант онд 2250.4 мянган төгрөгийн өрийг бүрэн барагдуулсан бөгөөд тайлант оны эцэст өрийн үлдэгдэлгүй байна. Тайлант онд өмнөх оны өр төлсөн гэж материалын зардал төлсөн байгаа нь хоорондын тооцоо хийгээгүй, санхүүгийн тайлангаар тайлагнаагүй байгаатай холбоотой зөрчил байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл оны эцэст 2209209.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Оны эхнээс 223231.4 мянган төгрөгийн тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Зэрэг сумын ЕБ-ийн сургуулийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 519989.3 мянган төгрөгөөр буюу 53.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 519989.3 мянган төгрөгийн орлогын өөрчлөлтөөс тусгай зориулалтын санхүүжилт 351060.9 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй хөрөнгийн орлого 168928.4 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 267720.6 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн зардал 100889.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардал 109031.3 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 57800.0 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бодлогын өөрчлөлтөөр бүртгэлийн бичилт хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1205331.8 мянган төгрөгөөр нийт зарлагыг 1205331.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардалд тусгай зориулалтын шилжүүлгээс 1057607.9 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 147323.9 мянган төгрөгөөр туслах үйл ажиллагааны орлогыг 400.0 мянган төгрөгөөр нийт үйл ажиллагааны зардлыг 1205331.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Зэрэг сумын ИТХ-ын 2020.09.23-ы 12/02 тогтоолоор төсвийн тодотгол хийж сургуулийн төсвийг тусгай зориулалтын шилжүүлгээс 1093335.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 141954.6 мянган төгрөг, өөрийн орлогоос 400.0 мянган төгрөг нийт 1235689.2 мянган төгрөгөөр тодотгож баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1235689.2 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 1093335.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 141954.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 400.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр тодотгожээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1235689.2 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 1093335.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 141954.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 400.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 1232893.0 мянган төгрөг зарцуулж 2025.2 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт гарган төсөвт төвлөрүүлсэн байна. Төсөвт төвлөрүүлэх дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны хэмнэлт болох 92621.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй урсгал зардалд тодотгол хийн зориулалт бус зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1232893.0 мянган төгрөг буюу 98% зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн боловч хөтөлбөрөөс хэмнэлт гаргасан байна.

Хөтөлбөр арга хэмжээний хэмнэлтийг хүснэгтээр харуулбал:

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,420.0
81801	Үндсэн үйл ажиллагааны зардал	9.9
81806	Хоол хүнс	0.5
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	595.2
ДҮН		2,025.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар БСУГ-аас 500.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 800.0 мянган төгрөг нийт 1300.0 мянган төгрөгийн орлого оруулсан байна.

Нэмэлт дансаар орсон 1300.0 мянган төгрөгийг эм, эмийн хэрэгсэл болон ариутгалын бодис авч бараа материалд орлого авсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 134 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 130, мэдээллийг огт оруулаагүй 1, мэдээлэл дутуу оруулсан 3 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 1 мэдээллийг байршуулаагүй байгааг залруулан мэдээллийг оруулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Зэрэг сумын сургуульд 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөвлөмжийг өгсөн байна. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	5	10,692.9	3	1,249.5	2	9,443.4	40
Нийт дүн	5	10,692.9	3	1,249.5	2	9,443.4	40

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар 383175.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 54447.4 мянган төгрөгийн алдаа залруулж 328727.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчлөөс 74230.4 мянган төгрөгийн 6 зөрчилд 3 төлбөрийн акт, 208177.1 мянган төгрөгийн 4 зөрчилд 1 албан шаардлага, 46320.3 мянган төгрөгийн 4 зөрчилд 3 зөвлөмж хүргүүллээ.

Залруулсан алдаа: Аудитаар тайлангийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлд 50000.0 мянган төгрөгийн санхүүжилт зөрүүтэй илэрхийлсэн, үр дүнгийн тайланд үлдэх өртөгтэй хөрөнгийн гарз буруу бичилт хийсэн 4447.5 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 74230.4 мянган төгрөгийн 6 зөрчилд 3 төлбөрийн акт, 208177.1 мянган төгрөгийн 4 зөрчилд 1 албан шаардлага бичлээ.

1. Авлага, өглөг

1.1. **Илрүүлэлт:** Цалингийн ашиг төсвөөс илүү төлсөн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, цалингийн зардал тайланд бодитоор илэрхийлэгдээгүй 2206.0 мянган төгрөг, аж ахуйн нэгжид усны төлбөр илүү шилжүүлж авлагаар

тусгаагүй төсвийн үргүй зардал гаргасан 3500.0 мянган төгрөг, хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэж байгаа дэлгүүрийн боорцог, гоймон, талх шинжилгээний бичиггүй, хүнс нийлүүлэх гэрээ байхгүй, мах, сүү нь гарал үүслийн бичиггүй, хүүхдийн хоолны талон батлуулаагүй хоол зарлагдсан 394.4 мянган төгрөг, түрээсийн орлогын 30-ийг төсөвт төвлөрүүлээгүй 360.0 мянган төгрөг, нийт 6460.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 03-р сарын 06-ны өдрийн 293 тоот тогтоолын 3.5-д "Түрээслүүлэгч нь түрээсийн төлбөрийн 30 хувийг төлбөр орсноос хойш 5 хоногийн дотор төсөвт төвлөрүүлнэ", Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн батламж мэдээдлүүдийг хангахгүй байна.

- 1.2. Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх 6460.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоох

2. Мөнгөн хөрөнгө

- 2.1. Илрүүлэлт: Ажлын байрны осол гараагүй байхад хуурамч материал бүрдүүлэн үйлдвэрлэлийн осол тогтоож нэг удаагийн тэтгэмж олгосон гэх иргэдийн мэдээллийг хянахад мэдээлэл нотлогдож, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, захирамж, тушаал шийдвэрэгүйгээр хүүхдийн хоолны хэмнэгдсэн төсөвт төвлөрүүлэх зардлаас нэг удаагийн тэтгэмжид төсвийн тодотгол хийн 57800.0 мянган төгрөг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажгаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх, Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 14-р зүйлийн 14.2.3-д" "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 42-р зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн батламж мэдээдлүүдийг хангахгүй байна.

- 2.2. Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх 57800.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, хуулийн байгууллагад шилжүүлэх

3. Хандивын хөрөнгө

- 3.1. Илрүүлэлт: Сургуулийн ойд зориулж хандив цуглуулан данс нээсэн боловч зарцуулалтын тайлан байхгүй данс бүртгэлд тусгаж тайлагнаагүй, байгууллагууд, ажилчдын өгсөн хандивыг хувь харилцах данс руу оруулж хөрөнгө аваагүй хувьдаа зарцуулсан байгаа 9970.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь

өмнө хянан баталгаажуулах, Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх гэсэн заалттай нийцэхгүй санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- 3.2. Шийдвэрлэсэн нь: Хандивын хөрөнгийг хувь иргэнээс гаргуулан тухайн байгууллагын дансанд төвлөрүүлэх 9970,0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоох

4. Бараа материал

- 4.1. Илрүүлэлт. Бараа материалын зардал шилжүүлэхдээ е баримтгүй гүйлгээ хийсэн, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, засвар ихтэй, шаардлага хангахгүй баримтаар гүйлгээ хийсэн 19500.5 мянган төгрөг,
- 4.2. Илрүүлэлт: ИТХ-ын 11-р хуралдааны шийдвэрийг үндэслэн Зэрэг сумын ИТХ -ын 15/02 тоот тогтоолоор ЕБС-ийн төсвийг тодотгож баталсан боловч төсөв зарцуулах зардлыг батлаагүй, тодотголоор хүүхдийн хоол, үдийн цайны хэмнэгдсэн зардлыг төвлөрүүлээгүй зориулалт бусаар зардал хооронд гүйлгэн зарцуулсан 92621.6 мянган төгрөг,
- 4.3. Илрүүлэлт: Үдийн цай нийлүүлж байгаа аж ахуйн нэгжтэй хийсэн гэрээ байхгүй, хүүхдийн ирц бүртгэсэн хуудас засвартай, анхан шатны баримт байхгүй 17427.3 мянган төгрөг,
- 4.4. Илрүүлэлт: Хөрөнгө материалын тооллого хийж үлдээгдлийг баталгаажуулаагүй, акталсан бараа материал устгасан дүгнэлтгүй, нярвын тайлан засвар ихтэй шаардлага хангахгүй байгаа 78627.6 мянган төгрөгийн зөрчил тус тус илэрлээ.

Энэ нь СС-ийн 216 тоот тушаалаар батлагдсан төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, НББ-д тусгах журмын 2-р зүйлийн 2.2.1-д "нэгжид ноогдох норм, нормативаар тооцсон төсвийн гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээ, багассанаас бий болсон /сургуулийн хүүхдийн тоо.../ зарцуулагдаагүй үлдээгдлийг төсвийн зарлагын хэмнэлд тооцохгүй, Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 42-р зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"

- 4.5. Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг арилгах албан шаардлага бичих

Аудитын зөвлөмж: Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 46320.3 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар хандиваар авсан хөрөнгө, цалингийн зардал, дотуур байрны хүүхдээс хурааж авсан мөнгөний зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1 Нягтлан бодох бүртгэл хөтлөлт :

1.1 Илрүүлэлт: Дотуур байрны хүүхдээс байр тохижуулах зориулалтаар мөнгө хурааж аваад хэрхэн зарцуулсан талаар тайлан байхгүй байгаа 4000.0 мянган төгрөг, сургуулийн ойд зориулж хандив цуглуулан данс нээсэн боловч зарцуулалтын тайлан байхгүй данс бүртгэлд тусгаж тайлагнаагүй 4198.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

1.2 Эрсдэл: Дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх, хөрөнгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй байх, санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдээгдэл хангагдахгүй байх

1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Бараа материал

2.1 Илрүүлэлт: Хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэж байгаа дэлгүүрийн боорцог, гоймон, талх шинжилгээний бичиггүй, хүнс нийлүүлэх гэрээ байхгүй, мах, сүү нь гарал үүслийн бичиггүй, хүүхдийн хоолны талон батлуулаагүй хоол зарлагдсан, хоолны талон засвар ихтэй 37244.1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

2.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй, байх дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх, хөрөнгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй байх, санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдээгдэл хангагдахгүй байх

2.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж е-баримтын хэрэгжилтийг хангаж ажиллах,

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3. Өглөг, авлага

3.1 Илрүүлэлт: Цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэл дутуу төлж өглөгөөр тусгаагүй, цалингийн карт хөтөлсөн ч гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй 877.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

3.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй, байх дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх, хөрөнгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй байх, санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдээгдэл хангагдахгүй байх

3.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Зэрэг сумын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/78/СТА-ТШЗТ
Шалгагдсан байгууллагын нэр:	Зэрэг сумын ЕБ-ийн сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	

1	Цалингаас суутгасан ашгийн татвар илүү төлж авлагаар тусгаагүй, хоолны талон засварласан, цэвэр бохир усны төлбөр илүү төлөөд авлагаар тусгаагүй төсвийн үргүй зардал гаргасан	6460.4	Төлбөрийн акт		
2	Ажлын байрны осол гараагүй байхад хуурамч материал бүрдүүлэн үйлдвэрлэлийн осол тогтоож нэг удаагийн тэтгэмж олгосон гэх иргэдийн мэдээллийг хянахад мэдээлэл нотлогдож, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, захирамж, тушаал шийдвэргүйгээр хүүхдийн хоолны хэмнэгдсэн төсөвт төвлөрүүлэх зардлаас нэг удаагийн тэтгэмжид төсвийн тодотгол хийн олгосон	57800.0	Төлбөрийн акт		
3	Сургуулийн ойд зориулж хандив цуглуулан данс нээсэн боловч зарцуулалтын тайлан байхгүй данс бүртгэлд тусгаж тайлагнаагүй, байгууллагууд, ажилчдын өгсөн хандивыг хувь харилцах данс руу оруулж хөрөнгө аваагүй хувьдаа зарцуулсан	9970.0	Төлбөрийн акт		
4	Бараа материалын зардал шилжүүлэхдээ е баримтгүй гүйлгээ хийсэн, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, хөрөнгийн тооллого хийгээгүй, үдийн цайны хүүхэд өдөр засвартай, хүүхдийн хоолны талон засвартай	208177.1	Албан шаардлага		
5	Хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэж байгаа дэлгүүрийн боорцог, гоймон, талх шинжилгээний бичиггүй, хүнс нийлүүлэх гэрээ байхгүй, мах, сүү нь гарал үүслийн бичиггүй, хүүхдийн хоолны талон батлуулаагүй хоол зарлагдсан	37244.1	Зөвлөмж	Захирал, Нягтлан бодогч	Ч.Төмөрмөнх, Б.Сарангэрэл
6	Цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэл дутуу төлж өглөгөөр тусгаагүй, цалингийн карт хөтөлсөн ч гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй	877.6	Зөвлөмж		
7	Дотуур байрны хүүхдээс байр тохижуулах зориулалтаар мөнгө хурааж аваад хэрхэн зарцуулсан талаар тайлан байхгүй байна, хандивын орлогын зарцуулалт байхгүй	8198.5	Зөвлөмж		
8	Үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилт болон зардлын данстыг буруу илэрхийлсэн, төсвийн гүйцэтгэл буруу тайлагнасан	54447.4	Залруулга хийсэн		
ДҮН		383175.2			

ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР